



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 399

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019, 2020 онд барьж ашиглалтад оруулсан нийт 6,960,898,437.00 (зургаан тэрбум есөн зуун жаран сая найман зуун ерэн найман мянга дөрвөн зуун гучин долоон) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Сэлэнгэ, Булган, Дорнод, Төв, Хэнтий, Ховд аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сэлэнгэ, Булган, Дорнод, Төв, Хэнтий, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцсэн актыг үндэслэн хөрөнгө эзэмшигчийг тогтоох, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

132001312

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн
399 дугаар тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчийн газарт бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалт ад орсон огноо	Тоо Хэмжээ	Хэмж их нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
Сэлэнгийн аймгийн орон нутгийн өмчийн газар						
1	Тариалангийн талбайн хашаа /Баянгол сум/	2019	50	км	6,898,805.40	344,940,270.00
2	Тариалангийн талбайн хашаа /Ерөө сум/	2020	40	км	6,500,000.00	260,000,000.00
3	Тариалангийн талбайн хашаа /Хүдэр сум/	2020	10	км	6,500,000.00	65,000,000.00
4	Тариалангийн талбайн хашаа /Орхонтуул сум/	2019	10	км	6,308,549.10	63,085,491.00
5	Тариалангийн талбайн хашаа /Баруунбүрэн сум/	2019	10	км	6,308,549.10	63,085,491.00
6	Тариалангийн талбайн хашаа /Хушаат сум/	2020	10	км	6,416,666.66	64,166,666.60
7	Тариалангийн талбайн хашаа /Зүүнбүрэн сум/	2020	20	км	6,416,666.67	128,333,333.40
8	Тариалангийн талбайн хашаа /Орхонтуул сум/	2020	20	км	6,300,000.00	126,000,000.00
9	Тариалангийн талбайн хашаа /Орхон сум/	2019	50	км	8,087,304.12	404,365,206.00
10	Тариалангийн талбайн хашаа /Цагааннуур сум/	2018	150	км	8,701,000.00	1,305,150,000.00
Хэсгийн дүн			370			2,824,126,458.00
Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар						
11	Тариалангийн талбайн хашаа /Хутаг-Өндөр сум/	2019	100	км	8,472,075.45	847,207,545.00
Хэсгийн дүн			100			847,207,545.00
Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар						
12	Тариалангийн талбайн хашаа /Халх гол сум/	2019	45	км	6,750,000.00	303,750,000.00

Хэсгийн дүн			45			303,750,000.00
Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар						
13	Тариалангийн талбайн хашаа /Сүмбэр сум/	2018	40	км	8,094,000.00	323,760,000.00
14	Тариалангийн талбайн хашаа /Баянцогт сум/	2018	20	км	8,710,380.90	174,207,618.00
15	Тариалангийн талбайн хашаа /Цээл сум/	2018	60	км	9,192,333.33	551,540,000.00
16	Тариалангийн талбайн хашаа /Жаргалант сум/	2019	50	км	6,241,908.64	312,095,432.00
17	Тариалангийн талбайн хашаа /Борнуур сум Нарт баг/	2019	4.07	км	6,241,908.64	25,404,568.00
Хэсгийн дүн			174.1	км		1,387,007,618.00
Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар						
18	Тариалангийн талбайн хашаа /Хурх сум/	2020	71.85	км	6,750,000.00	484,987,500.00
19	Тариалангийн талбайн хашаа /Биндэр сум/	2020	21	км	6,952,380.29	145,999,986.00
Хэсгийн дүн			92.85			630,987,486.00
Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар						
20	Хүнсний ногооны зоорь /Жаргалант сум/	2020	1000	тн	967,819,330.00	967,819,330.00
						967,819,330.00
Нийт дүн						6,960,898,437.00 (зургаан тэрбум есөн зуун жаран сая найман зуун ерэн найман мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг)